



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага гойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51 26 42-30
E-mail: info@audit.gov.mn

МЭДЭЭЛЭЛ ТЕХНОЛОГИЙН
ҮНДЭСНИЙ ПАРК ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
Ж.ЗОЛЗАЯА ТАНАА

2023.03.15 № 07/510

танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндэсний мэдээллийн нийгэмлэгийн агентлагаас буцалтгүй тусламж, хандиваар 510.2 сая төгрөгийн Цахим ур чадвар олгох төвийг байгуулж өгсөн байна.

Аудитын гол асуудал

Өмнөх оны аудитаар өр төлбөрийн үлдэгдлийг тулган баталгаажуулахад 2014-2015 онд үүссэн түрээсийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг Төрийн өмчийн хороонд /хуучин нэрээр/ өгөх өглөгөөр бүртгэсэн, тулган баталгаажуулах захидлаар ТӨБЗГ нь авлага бүртгээгүй, санхүүгийн тайланд тусгаагүй байсан тул Сангийн яамны 2022 оны 06/4419 тоот, Цахим хөгжил харилцаа холбооны яамны 2022 оны 03/126 тоот албан бичгүүд, Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын захирлын 2022 оны 1а-46 тоот тушаалыг үндэслэн 70.3 сая төгрөгийн өр төлбөрийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр хуримтлагдсан ашиг руу хаасан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын хүрээнд 87 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,606,875.52	10,016,223.52
1.1.2	Дансны авлага	281,897,254.51	223,948,121.08
1.1.6	Бараа материал	88,382,275.71	127,956,967.25
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,092,036.61	17,481.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	373,978,442.35	361,938,792.85
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,205,844,876.24	3,446,697,806.30
1.2.2	Биет бус хөрөнгө	673,280,000.00	673,280,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,879,124,876.24	4,119,977,806.30
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,253,103,318.59	4,481,916,599.15
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	101,030,139.08	50,149,573.81
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	121,194,215.67	21,300,060.92
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	468,847,069.30	775,702,438.71
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	691,071,424.05	847,152,073.44
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	3,848,610.15	3,334,457.15
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	3,848,610.15	3,334,457.15
2.2	Өр төлбөрийн нийт дүн	694,920,034.20	850,486,530.59
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн	1,021,630,200.00	1,021,630,200.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	3,207,725,219.64	3,207,725,219.64
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	789,494,381.42	789,494,381.42
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,460,666,516.67)	(1,387,419,732.50)
2.3.11	Эздийн өмчийн дүн	3,558,183,284.39	3,631,430,068.56
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	4,253,103,318.59	4,481,916,599.15

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,196,705,604.92	1,648,888,179.70
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг(алдагдал)	1,196,705,604.92	1,648,888,179.70
4	Түрээсийн орлого	620,417,440.51	845,850,583.30
6	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого /үндсэн хөрөнгө/	68,964,933.74	260,634,544.60
8	Бусад орлого	507,323,230.67	542,403,051.80
9	Борлуулалт, маркетингийн зардал	118,185,414.04	315,868,771.42
10	Ерөнхий ба удирдлагын зардал	860,079,782.22	1,034,041,744.00
12	Элэгдлийн зардал	208,272,647.80	297,452,881.04
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	1,767,614.09
17	Бусад зардал	7,670,000.00	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	2,497,760.86	3,292,397.33
19	Орлогын татварын зардал	229,808.03	329,239.73
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,267,952.83	2,963,157.60
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,068,272.25	2,963,157.60
23	Бусад дэлгэрэнгүй орлого	(199,680.58)	-
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	-
	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(199,680.58)	-
24	Орлогын нийт дүн	2,068,272.25	2,963,157.60

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,811,124,581.42	3,213,222,704.68	(1,468,232,273.96)	3,556,115,012.14
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	2,068,272.25	2,068,272.25
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(5,497,485.04)	5,497,485.04	-
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,811,124,581.42	3,207,725,219.64	(1,460,666,516.67)	3,558,183,284.39
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	2,963,157.60	2,963,157.60
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	70,283,626.57	70,283,626.57
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,811,124,581.42	3,207,725,219.64	(1,387,419,732.50)	3,631,430,068.56

СНАГ-2023/89/НА-СТА-ТӨА



Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,181,476,785.97	1,510,552,183.12
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	800,741,992.28	902,875,749.73
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	6,333,538.00	1,001,544.00
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	374,401,255.69	606,674,889.39
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,127,705,710.83	1,485,341,324.18
	Ажиллагчдад төлсөн	362,793,598.00	417,342,003.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	120,547,957.40	133,663,051.57
	Бараа материал худалдан авахад төлсөн	33,007,626.49	81,907,975.50
	Ашиглалтын зардалд төлсөн	119,344,811.92	134,726,923.73
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,148,250.00	9,219,820.00
	Газрын төлбөр	6,727,680.00	6,540,800.00
	Татварын байгууллагад төлсөн	195,752,570.42	246,069,762.09
	Даатгалын төлбөрт төлсөн	6,333,538.00	1,712,774.00
	Бусад мөнгөн зарлага	277,049,678.60	454,158,214.29
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	53,771,075.14	25,210,858.94
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,933,298.77	21,842,951.21
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	4,933,4298.77	21,842,951.21
	Хүлээн авсан хүүний орлого	-	-
	Хүлээн авсан ногдол ашиг	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	81,161,049.23	50,921,662.15
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	71,585,049.23	22,516,950.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	9,576,000.00	28,404,712.15
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(76,227,750.46)	(29,078,710.94)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	7,460,000.00	14,184,450.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	7,460,000.00	14,184,450.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
	Төрөл бүрийн хандив	-	-
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	-

Мэдээлэл технологийн үндэсний парк ТӨҮГ-ын 2022 оны санхүүгийн тайланд
хийсэн аудитын тайлан

3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,095,000.00	1,907,250.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	5,095,000.00	1,907,250.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	-	-
	Төлсөн ногдол ашиг	-	-
	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,365,000.00	12,277,200.00
4	Валютын ханшийн зөрүү	-	-
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(20,091,675.32)	8,409,348.00
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	21,698,550.84	1,606,875.52
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,606,875.52	10,016,223.52